


## 5.3 Багшаас хасах

Боловсролын удирдлага систем дээр багш гэж тодорхойлж нэмсэн багш нь багшаас болих, сургуулиас гарсан бол багшаас хасах үйлдлийг хийхэд ашиглана.

Багшаас хасах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.



2. Багшийн жагсаалтаас багшаас хасах багшийн нэрийг сонгоно.

3. Үйлдэл цэснээс **Багш, ажилтны мэдээлэл устгах** үйлдлийг дарна.


Багшаас хасах үйлдлийг хийх алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Багш**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Үйлдлийн арын сум дээр дарж **Багш, ажилтны мэдээлэл устгах** үйлдлийг хийхэд хэрвээ тухайн багш дээр нэмэлт мэдээлэл бүртгэлтэй бол дараах анхааруулгыг харуулна.

<p><b>Мэдээлэл</b></p> <p>Устгах боломжгүй. Хариуцсан анги, бүлэг бүртгэгдсэн байна.</p> <p>Тийм</p>	<p>Багшийн нэмэлт мэдээллийг устгасны дараа багшийг хасах боломжтой. Хариуцсан анги, бүлэг, хариуцсан анги, танхим, заадаг хичээл зэргийн бүртгэлийг хассаны дараа багшийг устгана.</p>
--	---

	<p>Тийм товчийг дарснаар багшаас хасагдана.</p>
--	---

 Багшийн мэдээлэл устгах

**Ч.Гантөмөр(Багш, математикийн)**-багшийн мэдээллийг устгахдаа итгэлтэй байна уу.

Тийм

Үгүй